

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ  
2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2024.05.10

Шивээговь сум

Д/Д	ЗДҮАХ-т тусгадсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Нийт хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая төгрөг/	Суурь	Хүрэх түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ эх үүсвэр/, /сая төгрөг/		Биелэлт	Хувь
							2024 он			
							Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв сая.төг		
<b>НЭГ. "КОВИД-19" ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО</b>										
<b>1.1. "Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.</b>										
1.	1.1.1. "Ковид-19" халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдал, хариу арга хэмжээг хангах ажлыг зохион байгуулна.	1	"Ковид-19" халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах.	2021-2023	Орон нутгийн хөгжлийн сан  Байгууллагын төсөв	хариу арга хэмжээ авч ажилласан.	Ковид-19-ын эсрэг хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийнэ. Хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-95	3.0	Сумын Онцгой комисс болон Аймгийн Онцгой байдлын газрын мэргэжилтний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Коронавируст халдвар /Ковид-19/ -ын хариу арга хэмжээний төлөвлөгөөний тодотголыг хийж, нийт 4 дэд бүлэг 10 хариу арга хэмжээг төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу 2024 оны хагас жилийн байдлаар: <b>Эрүүл мэндийн салбарын бэлэн байдлыг хангаж, эм тарианы нөөц хангалт-6 сарын нөөц хангалт-100%, хоол хүнсний нөөц-3 сар, нэг удаагийн хувцас хэрэгсэл хангалт-1 сар-100%, хүний нөөцийн хангалт-80%</b> байна. <b>Хүрсэн түвшин:</b> Коронавируст халдвар /Ковид-19/ -ын хариу арга хэмжээний төлөвлөгөөний дундаж биелэлт-93.3% Нөөцийн бэлэн байдал-100%	100
2.	1.1.2. Сумын онцгой комисс, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг чадавхжуулах, шаардлагатай тоног, төхөөрөмж, хамгаалалтын хэрэгслээр хангах арга хэмжээг зохион байгуулна.	2	Сумын онцгой комисс, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг сургаж чадавхжуулна.	2021-2024	Орон нутгийн хөгжлийн сан	сургаж дадлагажуулах ажил 2 удаа зохион байгуулсан.	Сумын онцгой комисс, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулна.	1.0	МУ-ын ЗГ-ын 339 дүгээр тогтоол "Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах журам", 340 дүгээр тогтоол "Гашгийн үед нүүлгэн шилжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх чиглэлээр <b>2024 оны 03 дугаар сарын 28</b> -ны өдрийн 16:00 цагт улс даяар зохион байгуулагдсан Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах арга хэмжээгээр зарлан мэдээллийн дуут дохиогоор <b>сумын 640 гаруй иргэд</b>	100

									<p><b>“Цугларах цэг”-т цуглаж</b> бүртгүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Мөн 2024 оны <b>05 дугаар сарын 08-ны</b> өдөр Аймгийн ОБГ-аас “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгт бэлдэх” журмын дагуу шалгалтыг зохион байгуулсан бөгөөд <b>сумын шуурхай штабын ажлын үйл явц, сумын мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний бэлэн байдалд үнэлэлт дүгнэлт өгч</b>, сайжруулалт хийх мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажиллаад байна.  <b>Хүрсэн түвшин:</b>          Зохион байгуулсан арга хэмжээний тоо-2 Чадавхжуулах сургалтын тоо-2 Хамрагдсан иргэдийн тоо-640 гаруй</p>	
3.			Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг шаардлагатай тоног, төхөөрөмж, хамгаалалтын хэрэгслээр хангана.	2021-2024	Орон нутгийн хөгжлийн сан, Засаг даргын нөөц хөрөнгө	Гал унтраах 3 төрлийн 10ш багаж нэмэгдсэн.	Хамгаалах хувцасаар хангана.	1.0	2024 оны эхний хагас жилийн байдлаар Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг шаардлагатай багаж төхөөрөмжөөр хангах ажилд 2.125.000 төгрөгийг зарцуулсан. <b>Хүрсэн түвшин:</b> Хамгаалах хувцасаар хангасан.	100
4.	1.1.3. Хүн амыг Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, сургууль, цэцэрлэгийн хүүхэд, стератегийн ач холбогдол бүхий	3	Хүн амыг Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх вакцинд хамруулна.	2021-2022	УТ	-	Насанд хүрэгчдийг Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх вакцинд хамруулна.	-	Ковид-19 халдвар буурсантай холбоотойгоор 2024 оны эхний хагас жилийн байдлаар Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх вакцинд хамрагдсан иргэн байхгүй байна.	-
5.	байгууллагын ажилтан албан хаагчдыг томуугийн вакцинд хамруулна.		Сургууль, цэцэрлэгийн хүүхэд, стератегийн ач холбогдол бүхий байгууллагын ажилтан албан хаагчдыг томуугийн вакцинд хамруулна.	2021-2024	Хувийн хөрөнгө оруулалт	-	Улирлын томуугийн вакцин 60 хүн тун		Сумын хэмжээнд 2-5 насны хүүхэд 344 хүүхэд улирлын томуугийн вакцинд хамрагдахаар байгаа бөгөөд томуугийн вакцин төлөвлөгөөний дагуу 2024 оны 10 дугаар сард хийгдэнэ.	-
6.	1.1.4. “Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгаа	4	“Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт,	2021-2024	Байгууллагын төсөв	-	Гарын авлага тараах, цахим орчинд мэдээлэл бэлтгэж түгээх		“Ковид-19” өвчний шинэ хувилбарын тархалтаас сэргийлэн эрүүл мэндийн байгууллагаас коронавирусын халдвараас сэргийлэх талаар сургалт	100

	сургалтыг зохион байгуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана.		сурталчилгаа зохион байгуулна.					суртачилгааг эрүүл мэндийн төвийн НЭМА цахим хаягаар, ЭМЯ-наас гаргасан богино хэмжээний бичлэг болон мэдээ мэдээллийг тогтмол явуулж 6 удаагийн постер оруулсан бөгөөд давхардсан тоогоор 956 удаагийн хандалттай байна. ЭМТөв нь ковидын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор халуурсан, ханиалгасан, мөн уушигны хатгаа өвчнөөр хэвтэн эмчлүүлэхээр ирсэн 7 иргэдээс ковидын түргэвчилсэн шинжилгээг авч өвчлөлөөс урьдчилан сэргийлэх гарын авлага, брошур тарааж гарын үсгээр баталгаажуулсан. <b>Хүрсэн түвшин:</b> Мэдээ мэдээлэл түгээсэн тоо: 6 Гарын авлага тараасан тоо: 87		
7.			Хариу арга хэмжээний бэлэн байдлын нөөцийг бүрдүүлнэ.	2021-2022	Улсын төсөв, Байгууллагын төсөв	–	Ковид-19 халдварын өвчлөлийн үеийн эм тариа, хамгаалах хэрэгсэлийн 1 сарын нөөцийг бүрдүүлсэн байна.	1.5 сая	Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны тушаалаар “Халдварт өвчлөлөөс сэргийлэх баг”-ийг томилгоожуулан, 2024 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг 4 зорилт 13 арга хэмжээтэйгээр төлөвлөөд байна. <b>Хүрсэн түвшин:</b> Төлөвлөгөөний хэрэгжилт-100% Нөөцийн бэлэн байдал-100% /1 сар/	100
8.	1.1.5. Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлж, сургууль завсардалтын эрсдэлийг тооцоолж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	5	Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг тодорхойлж, хичээл сургалтын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	2021-2024	Улсын төсөв, Байгууллагын төсөв	–	Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээг 1 удаа хийнэ.  Үнэлгээнд үндэслэн тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	-	Багш, ажилчдын нарийн мэргэжлийн эмчийн 8 төрлийн үзлэг, 9 төрлийн шинжилгээнд 44 багш ажилчид хамрагдаж, эрүүл мэндийн түвшинг тодорхойлон, сургуулийн эмч, СЭМТ-ийн эмч мэргэжилтнүүдийн хяналтанд эрүүлжүүлэх арга хэмжээ авч байна. <b>Хүрсэн түвшин:</b> Багш, сурагч, сургуулийн ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээнд нийт 821 багш, сурагчид хамрагдсан. Сургуулийн эмч “Эрүүлжүүлэх арга хэмжээ”-ний төлөвлөгөө гарган ажиллаж байна.	100

9.			Сургууль завсардалтын эрсдэлийг тооцоолж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	2021-2024		–	Сургууль завсардалтыг таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.		2024 оны эхний хагас жилийн байдлаар сумын хэмжээнд улирлын ханиад томуу, томуу төст өвчний дэгдэлт-10,000 хүн амд 74.0, салхинцэцэг өвчний дэгдэлт 20 тохиолдол буюу нийт 10,000 хүн амд 66.0 байна. Улсын дундаж 9.5%, аймгийн дундаж 17.2% байна. Иймд сумын Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч, багч, ажилчдад Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх сургалтыг 3 удаа зохион байгуулж нийт давхардсан тоогоор 850 хүүхдэд салхинцэцэг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт хийж, 3 ангид гарын ариун цэвэр сахиулах шингэн саван сальфеткаар ханган ажилласан байна. Мөн ЕБС-ийн давхардсан тоогоор 910 хүүхдэд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг 2024 оны 03 дүгээр сарын 25-29-ний өдрүүдэд хийгээд байна. <b>Хүрсэн түвшин:</b> Зохион байгуулсан сургалтын тоо-3 Хамрагдсан сурагчдын тоо-давхардсан тоогоор 1760	100
----	--	--	---	-----------	--	---	--	--	---	-----

**ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**Эрүүл мэнд**

**2.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.**

10.	2.1.1. Сумын эрүүл мэндийн төвийг оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангаж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	6	Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ	2021-2024	Улсын төсвийн хөрөнгө, Орон нутгийн хөгжлийн сан, төсөл хөтөлбөр	нийт 6.1 сая төгрөгийн 3 төрлийн тоног төхөөрөмжөөр хангасан.	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангана.	10.0	Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд сумын ЭМТөвд биохимийн бүрэн автомат анализаторын аппаратыг худалдан авахаар төлөвлөж, худалдан авах ажиллагаагаар 18,750,000 төгрөгөөр худалдан авахаар болсон. Урьдчилгаа төлбөр 50% хийгдэж, 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр тоног төхөөрөмжөө хүлээн авахаар гэрээгээ хийгээд байна. Мөн Дэлхийн банкны санхүүжилтээр. 5,676,300 төгрөгийн өртөг бүхий хог хаягдал ариутгах автомат	100
-----	---	---	--	-----------	--	---	--	------	---	-----

									<p>автоклавын иж бүрдэл, ус нэрэгч-2 ш, электрон жин, өндөр температурт тэсвэртэй бээлийн тагны кадас жийргэвчээр хангагдсан.</p> <p>Дэлхийн ЭМБ-ын санхүүжилтээр Дархлаажуулалтын кабинетын тоног төхөөрөмж-принтер, хүүхдийн ор, тарилгын тэргэнцэр, жижиг бикс, яаралтай тусламжийн дархлаажуулалтын цунх бикс, хүчилтөрөгчийн өтгөрүүлэгч нийт 1,524,725 төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдаад байна.</p> <p>Мөн сумын ЭМТ өөрийн байгууллагын санхүүжилтээр сахар хэмжигч тестийн аппарат-7 ш-210,000, холестрин үзэх тест аппарат-450,000 худалдан аваад байна.</p> <p><b>Хүрсэн түвшин:</b> Санхүүжилт авсан тоо-4 Шинээр авсан тоног төхөөрөмжийн тоо- 15</p>	
11.	2.1.2. Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулна.	7	Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх	2021-2024	Төсөл хөтөлбөр, Байгууллагын төсөв	төлөвлөсөн арга хэмжээ 82 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн.	Тухай жилийн төлөвлөсөн арга хэмжээний гүйцэтгэл 100 хувь	1 сая	<p>Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд эхний хагас жилийн байдлаар <b>3 төрлийн</b> арга хэмжээний хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ <b>“Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих”</b> арга хэмжээний хүрээнд төрсөн болон жирэмсэн 19 эмэгтэй хамрагдаж 0-3 сартай хүүхдийн асаргааны гардан үзүүлэлт, хүүхдийн хооллолт, жирэмсэн үеийн сэтгэл гутралаас урьдчилан сэргийлэх тухай мэдлэг олгож, хүүхдийн асаргааны багцыг олгож байна.</li> <li>➤ <b>“Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үзлэг, оношлогоо зохион байгуулах”</b> ажлын дагуу нийт-59 иргэнийг чих хамар хоолой, зүрх судас,</li> </ul>	100

								<p>эмэгтэйчүүдийн үзлэг оношлогоонд хамруулсан.</p> <p>➤ <b>“Улирлын чанартай халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах”</b> ажлын хүрээнд Салхинцэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар мэдлэг мэдээллийг ЕБС-ийн 985 хүүхдэд танилцуулж, 31 ангид бактерийн эсрэг гарын саван, гарын хуурай сальфетка бэлтгэн олгосон байна.</p> <p><b>Хүрсэн түвшин:</b> Зохион байгуулсан арга хэмжээний тоо-3 Хамрагдсан иргэдийн тоо <b>1046</b></p>	
12.	2.1.3. Хүн амыг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, эрт илрүүлэх үзлэг шинжилгээг сайжруулна.	8	Зонхилон тохиолдох халдварт бус, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, үзлэг, оношилгоог зохион байгуулна.	2021-2024	Улсын төсөв  Орон нутгийн төсөв	<p>Хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь-68.5</p> <p>Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх үзлэгт хүн амын 11.8 хувийг хамруулсан. Тэмбүүгийн илрүүлэг үзлэгт-25.9 хувь</p>	Вируст гепатит – 80%, хөхний хавдар – 86%, умайн хүзүүний хавдар-70%, Сүрьеэ- 75% БЗДХ/ХДХВ -70%	<p><b>Элэгний ВС вирус илрүүлэг</b>-нийт хамрагдвал зохих 40-65 насны 936 иргэнээс эхний хагас жилийн байдлаар 280 хүн буюу 30%, <b>БЗДХӨ-ний илрүүлэг</b> 18-60 нас хүртэл 2181 буюу ДОХ/ХДХВ, тэмбүүгийн халдвар илрүүлэгт 420 иргэн хамрагдаж 20%, <b>Сүрьеэгийн өвчлөлийн</b> илрүүлэгт эрсдэлт бүлгийн хавьтлын бүртгэлтэй-20 иргэний-25 сорьцыг хяналтад өгч, сөрөг-25 буюу хамрагдалтын хувь-100%, Сумын хэмжээнд сүрьеэгийн эрсдэлт бүлгийн иргэд болох уурхайн ажилчид-358 иргэн, сүрьеэгийн өвчлөлийн тохиолдлын хавьтлын 20 иргэн байна. Тандалт шинжилгээнд сард 5 сорьцыг, жилд 60 сорьц тээвэрлэхээс 29 сорьц тээвэрлэсэн буюу гүйцэтгэл 100% байна. Сүрьеэгийн хяналт эмчилгээг суманд 1 иргэнд хийж байна. <b>Умайн хүзүүний эсийн шинжилгээнд</b> хамрагдвал зохих-243 иргэнээс 30 иргэн хамрагдаж, хамрагдалт 12%. <b>Артерийн гипертензия</b> 18 наснаас дээш- 2319 иргэн хамрагдахаас-341 иргэн хамрагдаж,</p>	100

									хамрагдалт 14% байна. <b>Чихрийн шижин</b> илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих-35 аас дээш насны 1417 хамрагдахаас 296 иргэн хамрагдсан буюу 20% тус тус хамрагдаад байна. <b>Хүрсэн түвшин:</b> Урьдчилан сэргийлэх үзлэгийн тоо-7 Нийт хамрагдсан иргэдийн тоо-1607	
14.	2.1.5. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг ур чадварыг дээшлүүлж, гадаад, дотоодын давтан сургалтад хамруулах, тогтвор суурьшилтай ажиллуулна.	10	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг ур чадварыг дээшлүүлж, гадаад, дотоодын давтан сургалтад хамруулах, тогтвор суурьшилтай ажиллуулах.	2021-2024	Улсын төсөв  Байгууллагын төсөв, төсөл арга хэмжээ	–	Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг тасралтгүй сургаж, чадавхижуулна Гаднаас ирсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэнгүүдийг орон байраар хангана.	0.5 сая	Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг тасралтгүй сургаж, чадавхижуулах ажлын хүрээнд 2024 он гарснаар сумын <b>ЭМТөвийн 12 ажилтанг УБ хотод 3 удаагийн сургалтад, ГСА-ийн ЭМ-ийн салбарын 6 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 26</b> ажилтан хамрагдсан. Орон нутагт шаардлагатай мэргэжлээр шилжиж ажиллах нарийн мэргэжлийн хүний нөөц, бусад албан хаагчдыг ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлж, санхүүгийн болон орон байрны дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд 2024 оны эхний хагас жилийн байдлаар: Эрүүл мэндийн төв-Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хөдөө орон нутагт шилжин суурьшиж ажиллахаар ирсэн багийн эмчийн нийгмийн баталгааг хангах үүднээс орон нутагт ажиллах нөхцлийг бүрдүүлэн, түрээслэн амьдарч буй байрны түрээсийн төлбөрийг зургаан сарын хугацаагаар төлөөд байна. <b>Хүрсэн түвшин:</b> Сургалтад хамруулсан тоо-9 Хамрагдсан ажилчдын тоо-38 Сул орон тоонд улаанбаатар хотоос шилжүүлэн томилсон албан хаагчийн тоо-1 Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангасан байдал- 100%	100
15.	2.1.6. Сумын эрүүл мэндийн төвийн шинэ хуучин барилгын байруудыг холбож өргөтгөл хийх, тасаг		Сумын эрүүл мэндийн төвийн шинэ хуучин барилгын байруудыг холбон	2022-2023	Орон нутгийн хөгжлийн сан,	–	Эрүүл мэндийн төвийн шинэ хуучин барилгын байруудыг холбон гадна	20 сая	2024 оны ОНХСангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын саналд тус ажил эрэмбэлэгдээгүй тул 2025 оны хөрөнгө оруулалтын ажлын	-

	нэгжүүдийн тоог нэмэгдүүлж, хүүхдийн эмчилгээний тасаг нээх, гадна талбайг тохижуулна.	11	өргөтгөл хийж, гадна талбайг тохижуулах.		Байгууллагын төсөв		тохижилтын ажлыг хүлээн авах.		саналд тусгаж <a href="https://onhs.mof.gov.mn">onhs.mof.gov.mn</a> цахим сайтад оруулаад байна.	
16.			Тасаг нэгжүүдийн тоог нэмэгдүүлж, хүүхдийн эмчилгээний тасаг нээх	2021-2023	Улсын төсөв, төсөл арга хэмжээ	-	Эрүүл мэндийн төвд Хүүхдийн эмчилгээний тасаг нээж ашиглалтанд оруулах.	10.0 сая	2024 оны эхний хагас жилийн байдлаар шинээр Хүүхдийн эмчилгээний тасаг нээгдээгүй байна.	-
17.	2.1.7. Сумын хөдөөгийн багийн эмчтэй болох, тогтвор суурьшилтай ажиллуулах, нарийн мэргэжлийн үзлэг, оношлогооний чиглэлээр хөдөлгөөнт үйлчилгээ үзүүлэх, эх нярайн тусламж үйлчилгээг сайжруулна.	12	Сумын хөдөөгийн багийн эмчтэй болох, тогтвор суурьшилтай ажиллуулах.	2022-2024	Улсын төсөв		Хөдөөгийн багийн иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх.	-	Сумын хүн амын нарийвчилсан статистик тоон судалгаагаар 1 эмчид ногдох хүн амын тоо нь 1000 байна. Одоогоор 2 өрхийн их эмчтэйгээр үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Сумын бүх иргэд шаардлагатай эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж байна. <b>Хүрсэн түвшин:</b> Багийн эмч-2, Дотрын эмч -1	100
18.			Мобайл технологийн тусламж үйлчилгээг иргэдэд үзүүлэх.	2021-2024	Байгууллагын төсөв	Мобайл технологийн тусламж үйлчилгээг нэвтрүүлсэн.	Мобайл технологийн тусламж үйлчилгээг хөдөөгийн багийн иргэдэд үзүүлэх.	-	Хөдөөгийн иргэдэд ЭМТҮ-г явуулын байдлаар үзүүлж, 2024 оны эхний хагас жилийн байдлаар <b>3 удаа</b> малчны хотонд очиж үйлчилгээ үзүүлсэн бөгөөд тус үзлэг шинжилгээнд давхардсан тоогоор <b>71 иргэн</b> хамрагдсан байна. 71 иргэнээс <b>элэгний ВС вирус илрүүлэг, цусны сахар илрүүлэг, 3 төрлийн хавдрын илрүүлэг, НР илрүүлэг</b> хийсэн. <b>Хүрсэн түвшин:</b> Зохион байгуулсан арга хэмжээ-3 Хамрагдсан иргэдийн тоо давхардсан тоогоор 71	100
19.			Эх нярайн тусламж үйлчилгээг сайжруулна.	2021-2024	0	Жирэмсний эрт үеийн хяналтын эзлэх хувь-98 Нялхасын эндэгдлийн түвшин-0	Жирэмсний эрт үеийн хяналтын эзлэх хувь-98 Нялхасын эндэгдлийн түвшин-0		2024 оны эхний хагас жилийн байдлаар сумын хэмжээнд жирэмсний хяналтад <b>40 эх</b> байснаас <b>төрсөн эх 10</b> болж, жирэмсний <b>хяналтад 30 эх</b> байна. Тус жирэмсэн эхчүүд эхний 3 сартай жирэмсний хяналтад 100% орсон байна. Нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл-0% байна. <b>Хүрсэн түвшин:</b> Жирэмсний хяналт -100.0 хувь Нялхсын эндэгдэл-0 Төрөлхийн тэмбүү илрээгүй-100%	100



20.	2.1.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон ахмад настан, зорилтот бүлгийн иргэдийг эрүүл мэндийн оношилгоо, үзлэгт тогтмол хамруулна.	13	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон ахмад настан, зорилтот бүлгийн иргэдийг эрүүл мэндийн оношилгоо, үзлэгт тогтмол хамруулах.	2021-2024	Улсын төсөв, Байгууллагын төсөв, төсөл хөтөлбөр	Оношилгоо, үзлэгт хамрагдалтын хувь 20.0	Оношилгоо, үзлэгт хамрагдалтын хувь 80.0		“Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үзлэг, оношлогоо зохион байгуулах”-1 тушаал гарч нийт-42 иргэнийг чих хамар хоолой, зүрх судас, эмэгтэйчүүдийн үзлэг оношлогоонд хамруулсан бөгөөд үүнээс эмэгтэйчүүдийн хавдрын урьдал-3 онош тавигдаж, дээд шатны эмнэлэгт илгээгдсэн бөгөөд нэг эмэгтэй эдийн шинжилгээ авч хагалгааны заалт гарсан бөгөөд шинжилгээ бүрдүүлэн хагалгаа төлөвлөсөн байна. <b>Хүрсэн түвшин:</b> Зохион байгуулсан арга хэмжээ-1	100
<b>Биеийн тамир, спорт</b>										
<b>2.2. Нийтийн биеийн тамир, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хөгжүүлж, тамирчдын өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.</b>										
21.	2.2.1. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх ёс, зан үйлийг хэвшүүлэхэд нийтийн биеийн тамирыг чиглүүлэх, чийрэгжүүлэх талбай байгуулна.	14	Нийтийн биеийн тамирыг чиглүүлэх, чийрэгжүүлэх талбай байгуулна.	2022-2024	Байгууллагын төсөв, орон нутгийн хөгжлийн сан, төсөл хөтөлбөр	-	Нийтийн биеийн тамирын талбайн тоог нэмэгдүүлэх	20 сая	Сумын 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн 354,583,682 мянган төгрөгийн хөрөнгөөр Сумын 1-р багт хийгдэх нийтийн биеийн тамирын талбай /хөл бөмбөгийн талбай/ байгуулах ажлын техникийн тодорхойлолтыг баталж, сумын Засаг даргын А/122 дугаар захирамжаар үнэлгээний хороо байгуулагдаж, тус хорооны шийдвэрээр “Цагаан толгойн нуур” ХХК-г сонгон шалгаруулан 354,583,682 төгрөгийн гэрээг 2023 оны 09 дүгээр сарын 13-ний өдөр байгуулсан. Газрын асуудал үүсч тус ажлын явц сар гаран түр зогсож, 10 дугаар сарын 26-ны өдрөөс эхэлсэн бөгөөд гэрээг 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл сунгасан. Хөл бөмбөгийн талбайн 2024 оны ажил 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхэлсэн гүйцэтгэгдээд байна. <b>Хүрсэн түвшин:</b> Ажлын гүйцэтгэл 70 хувьтай.	70
22.	2.2.2. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	15	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021-2024	Байгууллагын хөрөнгө	төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 70	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-100		Биеийн тамир, спортыг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд эхний хагас жилийн байдлаар:	

						хувьтай хэрэгжсэн.		<ul style="list-style-type: none"> <li>➤ 2024 оны 05 дугаар сарын 18-ны өдөр сумын <b>Ахмадын хороо болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд</b> Гурван төрөлт спортын тэмцээнийг зохион байгуулж, <b>нийт 56 ахмад, 15 хөгжлийн бэрхшээлтэй иргэд</b> оролцоод байна. Тус тэмцээн нь Шагайн наадгай, Дардас, Даам гэсэн 3 төрлөөр зохион байгуулагдлаа.</li> <li>➤ Мөн аймгийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан 3 төрөлт спортын бага наадамд сумын <b>төсвийн байгууллагууд хамтран оролцсон.</b></li> <li>➤ 2024 оны <b>Улсын аварга шалгаруулах Жудо бөхийн тэмцээнд</b> аймаг болон сумыг төлөөлөн оролцсон 3 тамирчинд <b>300 мянган төгрөгийн дэмжлэг</b> үзүүлээд байна.</li> <li>➤ “Нөхөрлөл-2024” спортын 3 төрөлт бага наадамд сумын үе үеийн төлөөллийн <b>100 гаруй төгсөгч</b> оролцсон байна.</li> </ul> <p><b>Хүрсэн түвшин:</b> Төлөвлөгөөний хэрэгжилт 80%</p>	70
23.	2.2.3. Урлаг, спорт, сурлагаар амжилт гаргасан хүүхдийг дэмжинэ.	16	Урлаг, спорт, сурлагаар амжилт гаргасан хүүхдийг дэмжинэ.	2021-2024	Байгууллагын төсөв	—	Дэмжлэг үзүүлсэн хүүхдийн тоо-5	Урлаг, спорт, сурлагаар амжилт гаргасан хүүхдийг дэмжих ажлын хүрээнд 2024 оны <b>Улсын аварга шалгаруулах Жудо бөхийн тэмцээнд</b> аймаг болон сумыг төлөөлөн оролцсон <b>3 тамирчинд 300 мянган төгрөгийн</b> дэмжлэг үзүүлээд байна.	100

										Хүрсэн түвшин: Дэмжлэг үзүүлсэн хүүхдийн тоо-3	
Боловсрол											
2.3. Боловсролын үйлчилгээнд тэгш хамруулж, чанар хүртээмжийг сайжруулна.											
24.	2.3.1. Шивээговь сумын Ерөнхий боловсролын 320 хүүхдийн сургуулийн барилгыг ашиглалтад оруулж, гадна талбайг тохижуулна.	17	Ерөнхий боловсролын 320 хүүхдийн сургуулийн барилгыг ашиглалтад оруулж, гадна талбайг тохижуулна.	2021-2022	Улсын төсвийн хөрөнгө оруулалт		Сургуулийн барилгын ажлын явц 100%		Шинэ сургуулийн барилгын ажилд 2024 оны 3 сард <b>БШУЯ</b> болон бусад холбогдох газруудаас <b>хяналт шалгалт</b> хийгээд байна. Тус шалгалтаар Барилгын магадлагаа болон төсөвт өртөгийг дахин шинэчлэхээр болсон. Шийдвэрийн дагуу ажлыг гүйцэтгэгч “Говийн өгөөж” ХХК-тай 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр ажлыг хүлээлцэхээр гэрээг дахин шинээр байгуулаад байна.	-	
25.	2.3.2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарыг тогтвор суурьшилтай ажиллуулахыг бодлогоор дэмжиж, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлнэ.	18	Цахим зайн сургалтын платформ, хөгжүүлэн, багш нарын оролцоог дэмжиж, цаг хугацаа орон зайнаас үл хамааран суралцах боломжийг бүрдүүлнэ.	2021-2024	Улсын төсөв	-	Цахим хэлбэрээр мэргэжлийн болон ур чадварын сургалтанд хамрагдсан багшийн тоо-40		2023-2024 оны хичээлийн жилд сумын 3-р цэцэрлэгийн 4 багш 4 цахим хичээлийн боловсруулалт хийж ажиллаж байгаа бөгөөд ЕБСургууль нь LMS цахим сургалтын программыг ашиглан хичээл сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна. Уг программд 31 бүлгийн 834 суралцагчдын мэдээллийг оруулж, 45 багш нар хичээл сургалтын хөтөлбөр төлөвлөгөөгөө оруулан хэрэгжүүлж байна. Багш бүр LMS сургалтын прораммд цахим хичээлүүдээ байрлуулан ажиллаж байгаа бөгөөд цахим хичээл бэлтгэдэг 35 багш байна. 2024 оны 01 дүгээр улирлын байдлаар 62 цахим хичээл байршуулсан байна. <b>Хүрсэн түвшин:</b> Цахим хичээл бэлтгэсэн багшийн тоо-39 Цахим хичээлийн тоо-66	100	
26.			Багшийн мэргэжлийн чадварыг тасралтгүй дээшлүүлэх сургалтанд хамруулах.	2021-2024	Улсын төсөв, Байгууллагын төсөв	сургууль, цэцэрлэгийн 16 багш чадвар дээшлүүлэх сургалтанд хамрагдсан.	Сургалтанд хамрагдсан сургууль, цэцэрлэгийн багшийн тоо-20		Багшийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтад эхний хагас жилийн байдлаар: ➤ <b>Орон нутгийн хэмжээнд</b> 6 төрлийн сургалтад 32 багш, <b>үндэсний хэмжээнд</b> 4 төрлийн сургалтад 9 багш, <b>ажлын байран дах</b> 6	100	

									<p>төрлийн сургалтад 45 багш нар хамрагдсан байна.</p> <p>➤ БЕГ-аас зохион байгуулсан модуль сургалтад 11 багш 1 удирдах ажилтан хамрагдсан. Сургалтын арга зүйн судалгааг цэцэрлэгийн хэмжээнд 3 баг болон мэргэжлийн багш нарын хүрээнд зохион байгуулж арга зүйн сайжруулалт хийж ажилласан.</p> <p><b>Хүрсэн түвшин:</b> Сургалтанд хамрагдсан сургууль, цэцэрлэгийн багшийн тоо-98</p>	
27.	2.3.3. Орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж буй болон төгсөөд орон нутагтаа ажиллах оюутнуудыг аймгийн сургалтын төлбөрийн тэтгэлэгт хамруулна.	19	Орон нутагт шаардлагатай мэргэжлээр суралцаж буй оюутнуудын судалгааг гаргаж, аймгийн сургалтын төлбөрийн тэтгэлэгт хамруулах.	2021-2024	Аймгийн төсөв	–	Тэтгэлэгт хамруулах оюутны тоо -3 хүртэл		Орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж буй болон төгсөөд орон нутагтаа ажиллах оюутнуудад сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох ажлыг 03 дугаар улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.	-
28.	2.3.4. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг стандартын шаардлага хангасан гал тогооны тоног төхөөрөмжөөр хангана.	20	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг стандартын шаардлага хангасан гал тогооны тоног төхөөрөмжөөр хангана.	2021-2024	Улсын төсөв, Орон нутгийн хөгжлийн сан	–	“Үдийн хоол” хөтөлбөрийг бага ангид хэрэгжүүлнэ.  Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	10.0 сая	Сургуулийн үдийн хоолонд 425 суралцагч, дотуур байранд 28 хүүхэд эрүүл чанартай хоол хүнсээр хангагдан суралцаж байна. Хоол үйлдвэрлэл үйлчилгээнд ахлах тогооч 1 , тогооч 2, туслах тогооч 1 нийт 4 хүн ажиллаж байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар “Туркийн ард түмний буцалтгүй тусламж”-аар сумын ЕБС-ийн үдийн хоолны хоол үйлдвэрлэл болон үйлчилгээний заланд бүрэн хэмжээний засвар орсон. Хоол үйлдвэрийн бүх төрлийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Хоол үйлдвэрлэлийн түүхий эдийг суманд худалдаа үйлчилгээ явуулдаг “Оюу арвижих, дэлгэрэх” ХХК, “Чойр хайрхан”ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж нийлүүлэлтээ хийдэг.	100

									2024 оны 05 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн үдийн хоол, дотуур байрны хүүхдийн хүнсний материаллыг тендерт шалгарсан "Магнай алаг" ХХК-тай гэрээ байгуулан нийлүүлэлтээ хийж эхлээд байна. <b>Хүрсэн түвшин:</b> Үдийн цай хөтөлбөрийг АНБ-тай гэрээгээр гүйцэтгүүлсэн тоо-3 Төхөөрөмжөөр хангасан сургуулийн тоо-1 Бэлтгэгдсэн мэргэжилтний тоо-4	
29.	2.3.5. Сургуулийн сантехникийг шинэчилж, хуучирч муудсан шугамыг солино.	21	Сургуулийн сантехникийг шинэчилж, хуучирч муудсан шугамыг солино.	2021-2023	Орон нутгийн хөгжлийн сан, Байгууллагын төсөв	Сургуулийн сантехникийг 5 сая төгрөгөөр хэсэгчлэн засварласан.	Сургуулийн сантехникийг хэсэгчлэн засварлах. /Хуучин ажил/	10.0 сая	2022 онд сургуулийн сан техникийг засварлахаар төлөвлөсний дагуу 9 сард засварыг хийж 5 анги, ахлах бага ангийн корпусыг бүрэн засварласан. Байгууллагын төсвөөр 3.500.000, орон нутгийн орлогоос 3,5сая төгрөг зарцуулсан байна. <b>Хүрсэн түвшин:</b> 2022 оны ажил төлөвлөгөөний дагуу хийгдсэн.	100
33.	2.3.8. Боловсролын байгууллагын сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийнэ.	24	Боловсролын байгууллагын сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийнэ.	2021-2024	Улсын төсөв, Орон нутгийн хөгжлийн сан, хөтөлбөр төсөл арга хэмжээ, байгууллагын төсөв	7 сая төгрөгийн хөрөнгөөр 3 ш зөөврийн компьютер хандиваар авсан.	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангана.		2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ИТХ-ын 06 дугаар тогтоолоор <b>Төрийн байгууллагуудад шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авах</b> ажлыг 107,971,700 төгрөгөөр төсвийг баталсан. 2024 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн А/12 дугаар захирамжаар "Үнэлгээний хороо"-г 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр нээлттэй тендерийг цахим сайтад зарласан. 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр тендерийн нээлт хийж үнэлгээний хороогоор ирүүлсэн материалыг хянаж үзээд, "Санаа мед трейд" ХХК шалгарч 2024 оны 04 дугаар сарын 22-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнээс 3-р цэцэрлэгт шаардлагатай техник тоног төхөөрөмжийн тендерт 63.990.000 мянган төгрөгийн 16 нэр төрлийн тоног төхөөрөмж	70

									нийлүүлэхээр Санаа мед трейд ХХК-тай гэрээ байгуулсан гэрээнд тусгагдсан байна. Гэрээг 2024 оны 06 дугаар сарын 22-нд хүлээн авна. Хүрсэн түвшин: Ажлын явц 70%	
34.	2.3.9. Хүүхдийг эрсдлээс сэргийлэх зорилгоор сургууль, цэцэрлэгийг камержуулна.	25	Хүүхдийг эрсдлээс сэргийлэх зорилгоор сургууль, цэцэрлэгийг камержуулна.	2021-2023	Улсын төсөв, Орон нутгийн хөгжлийн сан, хөтөлбөр төсөл арга хэмжээ, байгууллагын төсөв	цэцэрлэгийн 9 бүлэг камер суурилуулсан.	Сургууль, цэцэрлэгийн камерын тоог нэмэгдүүлнэ.	10.0 сая	2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ИТХ-ын ээлжит бус 26 дугаар хуралдаанаар сумын төвд байрлуулсан хяналтын телекамерыг засварлах, шинээр нэмж суулгах, шилэн кабел татах зэрэг ажлуудыг хийлгэхээр 19 сая төгрөгний санхүүжилттай ажлын худалдан авах ажиллагаа зарлаад байна. <b>Хүрсэн түвшин:</b> Сумын төвд байрлуулсан хяналтын телекамерыг засварлах, шинээр нэмж суулгах, шилэн кабел татах ажлын төсвийг зарлуулсан. Тендерийг шалгаруулахаар ажиллаж байна.	30
35.	2.3.10. 150-200 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлэх, санхүүгийн асуудалыг шийдвэрлэх.	26	150-200 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлэх, санхүүгийн асуудлыг шийдвэрлэх.	2022-2024	Улсын төсөв	цэцэрлэгийн барилгын зураг төсвийн ажил хийгдсэн.	150-200 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгын ажлыг хүлээн авах		Шивээговь сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг "Монничко" ХХК хийж гүйцэтгэж байна. Барилгын ажил үе шатны ажлын хуваарийн дагуу цутгалт дүүргэлтийн ажил хийгдэж, 2023 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн барилгын дээврийн дулаалга, дээврийн ажил, цахилгааны шугам дүүргэлт, хаалга, цонх хийх ажлууд хийгдээд байна. 2023 оны улсын төсөвт 630 сая төгрөг тусгагдсан бөгөөд нийт төсөвт өртөг 2.3 тэрбум төгрөг зарцуулагдаад байна. <b>Хүрсэн түвшин:</b> Барилгын ажлын гүйцэтгэл 80% 2024 онд үлдэгдэл ажил үе шатны хуваарийн дагуу барилгын ажил хийгдэж 2024 оны 9-р сарын 1-ний өдөр гүйцэтгэгч тал хүлээлгэн өгөхөөр хэлэлцсэн.	100
36.	2.3.11. Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн хамран сургалтыг 100 хувьд хүргэх.	27	Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн хамран сургалтыг нэмэгдүүлэх	2021-2024	Улсын төсөв, байгууллагын төсөв	Хамран сургалтын хувь – 86	Хамран сургалтын хувь – 90		3-р цэцэрлэгийн 2023-2024 оны хамран сургах тойргийг шинэчлэн тогтоосон. Сумын хэмжээнд 2-5 насны 344 хүүхдийн судалгаа гарсан бөгөөд үүнээс <b>293 хүүхэд цэцэрлэгт</b> хамрагдаж, өөр орон	

									нутагт 31 хүүхэд оршин сууж байна. <b>Цэцэрлэгийн хамран сургалт 94.5% тай байна.</b> Байрны багтаамжаас хамаарч яслийн бүлэг нээх боломжгүй байгаа тул явуулын багшийн сургалтыг зохион байгуулж, нийт 14 хүүхэд хамрагдаад байна. <b>Хүрсэн түвшин:</b> 3-р цэцэрлэгийн хамран сургалтын хувь- 94.5% Явуулын багшийн сургалтад хамрагдсан хүүхдийн тоо-14	100	
37.	2.3.12. Цэцэрлэгийн бүлгүүдийн ном, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайн хангамжийг нэмэгдүүлнэ.	28	Цэцэрлэгийн бүлгүүдийн ном, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайн хангамжийг нэмэгдүүлнэ.	2021-2025	Улсын төсөв, Орон нутгийн хөгжлийн сан, хөтөлбөр төсөл арга хэмжээ, байгууллагын төсөв	-	Шаардлагатай хэрэглэгдэхүүнийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	5.0 сая	2024 оны хагас жилийн байдлаар сумын Орон нутаг хөгжлийн сангаас 11.2 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх шатандаа явж байна. Их соёл Эх үндэс хөтөлбөрийн хүрээнд 01 дүгээр сард 5 багш shogom book-ээр хангагдсан. <b>Хүрсэн түвшин:</b> Шинээр нэмэгдсэн тоног төхөөрөмжийн тоо-5	100	
38.	2.3.13. Цэцэрлэгийн гадна тоглоомын талбайг өргөтгөнө.	29	Цэцэрлэгийн гадна тоглоомын талбайг өргөтгөнө.	2022-2023	Улсын төсөв, Байгууллагын төсөв	-	Цэцэрлэгийн гадна талбайг өргөтгөнө.		2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ИТХ-ын 06 дугаар тогтоолоор Цэцэрлэгийн хашааг шинэчлэн барих ажлыг 160,000,000 төгрөгөөр төсвийг баталсан. Сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/16 дугаар захирамжаар “Үнэлгээний хороо”-г 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр нээлттэй тендерийг цахим сайтад 2 удаа зарласан. Хуулийн хугацаанд тендерийн нээлт хийж, ирүүлсэн материалыг хянаж “Монничикон трейд” ХХК шалгарч гэрээ байгуулан ажил эхлээд байна. <b>Хүрсэн түвшин:</b> Ажлын гүйцэтгэл 70%	70	
<b>Хөдөлмөр, нийгмийн хамгаалал</b>											
<b>2.4. Хүн амын хөгжлийг хангаж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдэл ядуурлыг бууруулна.</b>											
40.	2.4.1. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох, судалгаанд үндэслэн нийгмийн	31	Нийгмийн халамжийн үйлчилгээг	2021-2024	Улсын төсөв	Зорилтот бүлгийн иргэдэд нийгмийн	Зорилтот бүлгийн иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг		2024 оны эхний хагас жилийн байдлаар Нийгмийн халамжийн 9 төрлийн үйлчилгээг үйлчилгээг 158 авсан байна.	100	

	халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэнэ.		зорилтот бүлэгт хүргэнэ.			халамжийн үйлчилгээг тогтмол хүргэн ажилласан.	чирэгдэлгүй хүргэсэн байна.		Хүрсэн түвшин: Халамжийн үйлчилгээ авсан иргэдийн тоо-158 Үйлчилгээтэй холбоотой гомдол санал гараагүй байна.	
41.	2.4.2. Орлого багатай өрхийн ажил эрхлэхгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтанд хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	32	Ажилгүй ажил олоход хүндрэлтэй иргэдийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулна.	2021-2024	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	-	Мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамрагдсан иргэний тоо-10 Хөдөлмөрт бэлтгэх сургалтанд хамрагдсан иргэний тоо-10		2024 оны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр төсөл хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй иргэдийг хамруулах сургалтын бүртгэл хийгдэж байна. Тус сургалт нь 5 дугаар сарын 27 эхлэн явагдна.	-
42.	2.4.3. Тусгай хэрэгцээт иргэдэд шинээр баригдаж байгаа зам, талбай, барилга, байгууламжид саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.	33	Тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан дэд бүтцийг сайжруулж, шинээр баригдаж байгаа зам, талбай, барилга, байгууламжид саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ	2021-2024	Улсын төсөв  Орон нутгийн төсөв	-	Шинээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын ажлуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг бүрэн тусгана. Аж ахуйн нэгж, албан байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ авах орчныг бүрдүүлнэ.		Хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчилгээ авахад ямар нэгэн саадгүй орчин бүрдсэн болно. Орон нутгийн хөгжлийн сангийн 5 сая төгрөгийн хөрөнгөөр <b>“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өрөөний тохижилт”</b> -ийн ажлыг хийж, сумын <b>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо</b> буюу <b>нийт 150 иргэн</b> тус өрөөндөө үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн шинээр баригдаж буй <b>сургууль, цэцэрлэг, аж ахуйн нэгжийн</b> барилга угсралтад ХБИ-ийн үйлчилгээ авах саадгүй орчин бүрдүүлэх хэсгийг тусгуулан ажиллаж байна. <b>Хүрсэн түвшин:</b> Шинээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын 2 ажилд ХБИ үйлчлүүлэх саадгүй орчныг тусгуулсан.	100
43.	2.4.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэн, 300-аас доошгүй иргэдийг байнгын, 500-аас доошгүй иргэдийг түр ажлын байраар хангана.	34	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэн иргэдийг ажлын байраар хангаж, ядуурлыг бууруулна	2021-2024	Байгууллагын төсөв	байнгын 66, түр 51	Байнгын ажлын байр- 10-аас доошгүй  Түр ажлын байр -10-аас доошгүй		“Нэг өрх-Нэг ажлын байр” арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөөд байна. ✚ Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа /нийтийг хамарсан ажил/ ✚ Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг ✚ Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох санхүүгийн дэмжлэг	100



									<ul style="list-style-type: none"> <li>✚ Иргэн, аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэг</li> <li>✚ Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ</li> <li>✚ Ажил олгогчийг дэмжих тухай</li> </ul> <p>Тус ажлууд нь төлөвлөгөөгөөр 06 дугаар сараас хэрэгжихээр батлагдсан байна. Мөн Орон нутгийн шилжин ирээгүй хөдөлмөр эрхэлж буй иргэдийн судалгааг гаргаж 2024 оны эхний хагас жилийн байдлаар суманд 45 албан хаагч, тэдгээрийн хүүхэд 17, нийт 62 иргэн суманд шилжин ирээд байна. Шилжин ирсэн 45 иргэнийг ажиллаж буй салбараар нь ангилвал:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Ерөнхий боловсролын сургуульд 10, “Шивээ-Овоо” ХК-д 15, Сургуулийн өмнөх боловсролд 4, Бусад байгууллагад 16 иргэн ажиллаж, шинээр шилжин ирээд байна.</li> </ul> <p>Аймгийн ХХҮГ-аас хэрэгжүүлдэг нийтийг хамарсан ажлын хүрээнд түр ажлын байрыг бий болгодог. Эхний хагас жилийн байдлаар нийтийг хамарсан түр ажлын байранд 20 иргэн ажиллаж эхлээд байна.</p> <p><b>Хүрсэн түвшин:</b> “Нэг өрх-Нэг ажлын байр” арга хэмжээний төлөвлөгөөг гарган батлуулаад байна. Шинээр ажилд томилогдсон төрийн албан хаагчийн тоо-15 Түр ажлын байр-20</p>
--	--	--	--	--	--	--	--	--	---

**Үндэсний бахархал, өв соёл**

**2.5. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёл урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.**

44.	2.5.1. 250 хүний суудалтай соёлын төвийг шинээр барих ажлын санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлнэ.	35	250 хүний суудалтай соёлын төвийг шинээр барих ажлын санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлнэ.	2022-2024	Улсын төсөв, орон нутгийн хөгжлийн сан	2014 онд зураг төсөв хийгдсэн.	Шивээговь сумын Соёлын төвийн барилгын ажлын санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлэх. Барилгын ажлыг эхлүүлэх	Аймгийн Засаг дарга Г.Батсуурь 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа цэцэрлэг сургуулийн барилгын ажлын явцтай танилцаж, иргэдтэй хийх уулзалтын үеэр сумын Соёлын төвийн барилгын ажлын зураг төсвийг танилцуулан	-
-----	--	----	---	-----------	--	--------------------------------	---	---	---

									гардуулан өгсөн. 2024 оны эхний хагас жилийн байдлаар хийгдсэн арга хэмжээ байхгүй.	
